

Ж. Өлзий

«БАРГА» ГЭДЭГ НЭРИЙН ҮҮСЭЛ

Аливаа нэгэн улсын өвөг аймаг ястан, үндэстний нэрийг судлах ухааныг угсаатны нэр зүйн буюу этнонимика гэдэг. Энэ нь эртний грек хэлний этнос (ард) ним (нэр) ика (зүй ухаан) гэсэн утгатай хэсгээс үүсэлтэй шинжлэх ухааны нэр томъёо юм.

Үүнд: Барга ардын Борга хэмээх нэр бол монголын болон гадаадын түүх, шасдирт дээр үеэс тэмдэглэгдсээр иржээ. Эртний хүннү улсын үед баргын тэргүүн нь Боргуужин гэдэг хүн байсан хэмээхээс гадна Боргуужин хэмээх аймаг ч байсан гэдэг. Тан улсын үед Ба-еэ-гү гэж нэрлэж байжээ¹. Монголын тал нутгийн умард хэсэгт нилээд олон хүннү нар үлдсэн байна. «Вэй улсын судрын жүжү хэмээх жужаны шасдирт» өгүүлсэн нь жүжү-гийн «баруун хойт талд хүннүгийн үлдэгдэл хүмүүс буй. Улс нь баян бөгөөд чийрэг, аймгийн удирдагчийг Ба-е-жи» гэж нэрлэдэг. Тэд нар олон нийтээрээ Шэлүнг зохиосон. Шэ-лүн бол Ан-гэн голд тэд нарыг тосож байлдан ихэд ялсан дараагаар нь тэд нар Шэлүний харьяанд нэгдсэн. Энэхүү Ба-еэ-жи гэдэг нь дуудлагын хувьд Хожуу-Тангийн үед Ба-еэ-гү-тэй маш адил юм гэжээ.

Манай эриний 696 оны үеэр Киданы² харьяалагдаж байсан Түрэг улсын эзэлсэн Тогус, Огуз, Байергу, Байергужин, Баргуужин зэрэг олон аймаг, Түрэг улсын хааныг эсэргүүцсэн 714—717 онд өргөн хөдөлгөөн гарсан байжээ. Түрэгийн хаан Мочжо бослого үймээнийг хатуугаар дарахыг оролдсон боловч 716 онд өөрөө Байергү нарт алагджээ.³ Энэхүү аймаг нь Байгал нуурын зүүн эргээр Ба-еэ-гү хэмээх овогтон амьдарч байсан мэдээ тан шу хэмээх хятадын он дарааллын бичгийн дотор бий. Түрэгийн хаадын булшны бичигт энэ овогтон Ба-еэ-гү гэж нэрлэгдсэн байдаг. Энэ овогтон бол 11—12-р зууны үед тэр хавиар нутаглаж байсан Боргууд болох нь бүрэн баттай юм гэж Буриадын түүхийн 1-р ботьд бичжээ.⁴

Тийнхүү «Тун-жиян ган му» бичигт Ли овогт Тан улсын үед Ба-еэ-гу хэмээх нэгэн хүчирхэг аймгийн үйл явдлыг тэмдэглэсэн нь даруй Барга аймаг мөн болно гэжээ. Түүнээс одоо нэрлэгдэж байгаа Баргажин аймаг болон Түмэд аймаг бол Баргын салбар мөн гэж бичиж байна.⁵ Үүнээс үзэхэд маш эртнээс нааш Баргажин «Ба-еэ-гу» гэж нэрлэгдэн байжээ.

Түрэг үгэнд Борой чоно⁶ барах урт үстэй сонор соргог анч нохойн хамгийн шилдгийг Барах гэж нэрлэнэ.⁷ Үүнээс гадна «Жоу улсын судрын» түцзюе хэмээх түрэгийн бүлэгт өгүүлсэн нь Түрэгийн дээд өвөг

¹Цзю Тан шу хуучин Тан улсын бичиг. 145, 16-р дэвтэр, 18-р тал (хятад хэлээр).

²Ма-чан-шү, Бэ-ди болон хүннү, 149-р тал. Бээжин, 1962 он.

³Х. Пэрлээ. Кидан нар тэдний монголчуудтай холбогдох нь, УБ., 1959, 32-р тал.

⁴История Буряд-монгольской АССР. Улан-Удэ, 1954, т. I, 42—43-р тал.

⁵Эрхэмбат, Бага аймгийн товч түүх. 1945 он, гар бичмэл. 1—2-р талд монгол хэлээр.

⁶Древнетюркский словарь. 118—1969-р тал.

⁷Мөн толийн 83-р тал.

нь Зин-Шидүг чононоос төрсөн гэж бичжээ. Түрэг улс байгуулагдаад төрийн далбаа дээрээ чонын алтан дүрс зурсан байна.¹

Үүнээс үзэхэд чоно нохой бол эрт дээр үеэс хий бишрэлийн үүднээс бөө мөргөлтөнд шүтэгдэн улсын сүлд, онгон эзэн гэж хүндэтгэгдэж ирсэн явдал үнэн байна.

Түүнчлэн Зөвлөлтийн эрдэмтэн Ц. Б. Цыдендамбаев буриадын түүхийн эх зохиол болон овгийн эх үүсвэрийн тухай эрдэм шинжилгээний чухал ач холбогдол бүхий томоохон зохиолыг туурвисан байна. Ц. Б. Цыдендамбаев энэ зохиолдоо: Эртний түрэгүүд, буриадын өвөг дээдсийг захиран тэдэнтэй нягт холбоотой байсныг дурдаад «бас түрэгүүд өөр омогтны нэрийг өөрийн түрэг хэлээр орчуулан дуудах заншилтай байсан сонирхолтой баримт тохиолддог. Жишээлбэл, түрэгүүд, баргуудыг байыркы гэдэг байжээ»² гэсэн байна.

Мөн эрдэмтэн Б. Б. Барадинаас 1927 онд «булагад гэдэг үг бол баргуд гэдэг үгийг эртний хягадаар бичсэний хувилбар юм»³ гэж бичсэнийг Ц. Б. Цыдендамбаев няцааж бичихдээ: «Энэ бол «р» гийгүүлэгч «л»-ээр солигдох боломжтойн хувьд зөв боловч, хятадууд үгийн эхэн үеийн «а»-г «ү»-гээр, эцсийн үеийн «у» эгшгийг «а»-гаар ямар үндэстэй солих билээ. Баргууд гэдэг овгийн нэрийг хятадаар дуудсан хувилбарын тухай энэ санал ул үндэслэлгүй юм. Хятадууд, баргуудыг байегу (түрэгийн байыркы гэдэгтэй жишиж үз) гэдэг нь түүхийн утга зохиолоос тодорхой байгаагаас гадна хятадын эх зохиолын орос орчуулгыг үзэхэд баргуд, булгад хоёрын аль аль нь байдаггүй юм»⁴ гэжээ. Иймд баргуд гэдэг үг буриадын өөр овгийн нэр булгад гэдэгтэй холбоотой ажээ.

Баргуд, баргуужин төхөм гэдэг нэрсийн талаар зарим эрдэмтний тайлбарласныг үзвэл XII—XIII зууны үед Байгал нуурын өмнөт хэсгийн хойт тал болон Байгал нуур хавийн газрыг Баргуужин төхөм гэж монголчууд нэрлэж байсан гэж Г. Н. Румянцев бичжээ. XIV зууны үеийн Перс улсын нэрт түүхч Рашид-ад-Дин, Сэлэнгэ мөрний хавиар нутагласан ардыг баргууд, баргуужин гэж монголчууд нэрлэдэг байсныг дурдсан бий. Тэрчлэн буриадууд баргалжин, баргуужин гэж нэрлэдэг байна. Баргалжин гэсэн үг бол Сэлэнгэ мөрнөөс баруун хойш оршдог битүү ой модтой, хүн цөөн суудаг хязгаар газар билээ. Энэ газар анх очиж, суурьшсан хүнийг баргууд гэж нэрлэсэн байна.⁵ Хожим тэнд Хори, Тулас овгууд очиж суурьшсанаас барга гэдэг нь баргууд болж, төхөм гэдэг нь баргэ буриадуудын хэлээр эрд (нөхөрт) очсон хүүхний төрсөн нутаг болон нам доор газрыг гөхөм гэж хэлэх бөгөөд төхөм гэдэг нь түүний ах дүүгийн гэрийг хэлдэг юм гэж зөвлөлтийн эрдэмтэн Т. А. Бертагаев хэл зүйн талаас нь авч бичсэн байна.⁶ Мөн «Юан улсын судрын» гучдугаар

¹Ма Чаншив, Түрэг хүн болон Түрэгийн хаант улс, Шанхай, 1957, 5—6-р тал.

²Ц. Б. Цыдендамбаев. Бурятские исторические хроники и родословные (Историко-Лингвистическое исследование) г. Улан-Удэ, 1972, 279-р тал.

³Б. Б. Барадин. Буряты-монфлы «Бурятоведение», 1927, № 3—4, 45-р тал.

⁴Ц. Б. Цыдендамбаев. Дээр дурдсан зохиол, 283-р тал.

⁵1-р зууны үед Энэтхэгийн орчин оронд тэрсүүдийн ах дүү зургаан багш бөө нар гэгч Шигмуни бурхантай ид, шид, увидасаараа тэмцэлдэж ялагдаад, тэрсүүдийн 6 багшийн отгон дүү бөө нь тангараг өгч, шавь болохгүйн тулд тэндээс оргон зайлж, Байгал нуурын өмнө захад хүрэлцэн ирсэнд тэр нутгийн ардууд усны их үерт автаж, хүн малын үхэл, зовлон болж байсан учир шинээр морилон ирсэн багш бөөд очиж, усны үерийн гай гамшгаас эсэн мэнд гаргахыг гуйж айлтгасанд тэр багш бөөгөөс одоо аль хэр хүн үхээд байна гэж асуусанд олон хүн ард, мал үхэж «барах» дөхөж байна гэж хариулсан үгээр «барах» ардыг барга гэдэг нэрийн үүсэл эндээс гарсан гэсэн домог байдаг.

⁶Т. А. Бертагаев. Филология и история монгольских народов, М., 1958, 173—174-р тал.

дэвтэрт Бараху гэдэг аймгийн тухай бичжээ.¹ Үүнээс гадна хуучин баргыг Чивчин барга гэдэг. Чивчин барга нь овог, төрлөөс яах аргагүй үүссэн нэр гэж бичжээ.²

Зарим судлаачид Их Хянганы нуруунаас баруун тийш Зөвлөлт, Монголын хил хүртэлх Хар мөрөн мужийн хэсгийг Хөлөнбуйрын Барга гэж нэрлэж тэмдэглэсэн байдаг. Энэ нь газар зүйн шинж байдалтай болсон байна. Ер барга хэмээх нэрийн дор Хөлөнбуйрын Барга гээд хуучин барга (чивчин), солон барга (эвенк). монгол буриад (барга, буриад, шинэ барга, өөлд, шинэхэний буриад, орчоон, дагуур нэр багтаж байдаг юм. Зарим судлаач нар Хөлөн нуур, Буйр нуур гэдэг хоёр их нуурын нэрээр Хөлөнбуйр гэдэг нь албан ёсны нэр бөгөөд ардын нэр нь барга гэж хэлдэг хэмээн тайлбарлан бичсэн байдаг. Харин зарим ном зохиолд «барга монголын хэлээр орчуулав» гэсэн зүйл ч байдаг. Гэвч одоо болтол энэ нэр бүрэн төгс оновчтой тайлбарлагдаагүй байсаар байна».³ «Бас монголчууд лугаа яс махны хэлхээ бүхий салаа мөчир болох барга монголыг ардууд барга гэж нэршүүлсэн байна. Барга хэмээх үг нь бөөгийн шашинтан болох нэгэн овог буюу Халх Монголд бүддийн шашин мандсан байх үед тэд нар бөөгийн мөргөлтэй байсны улмаас барга гэж нэршсэн юм» гэж «Манж Монголын холбогдолтой материалууд» гэдэг номонд бичжээ.⁴ Түүнчлэн японы «Манж монголын бүрэн бичиг» гэдэг зохиолд: «Шинэ Барга бол XVII зууны үед Халхын Сэцэн хан аймагт байжээ. Дээр үед Гадаад Хянганы нурууны баруун хойт хормойд нутаг, билчээртэй байсны улмаас 1796—1820 (Чин улсын Сайшаалт Ерөөлтийн үед) онуудад улмаар өмнө тийш шилжин нутаглаж, сүүлээр тосгон айл байгуулан Манжийн найман хошууны зохион байгуулалтанд шинээр орсон тул Шинэ барга хэмээх нэртэй болсон байна. Хожим ус, өвсний тунгалаг сэрмүүн, сайхныг сонгон шилжин нүүдэллэж нутагласаар Имин голын хоёр хөвөөгөөр нутаглах болжээ. Харин тэд нар лам нарыг хичээнгүйлэн шүтдэг заншилтай тул амь насаа бурханд даатгадаг байна. Энэхүү хуучин, шинэ хоёр барга үг хэлний талаар харилцан нэвтэрч ярилцдаг юм. Гэвч хуучин барга бол шинэ баргыгаа гал, усны адил үзэж түүнийг зэрлэг барга гэж хэлдэг байна» хэмээн бичжээ.⁵

Шинэ, хуучин хоёр барга харилцахдаа гал, усны адил үзэлцдэг байсан гэдэг бол Чин улсын феодалын нийгмийн төрийн бодлого нь ижил нэгэн үндэстэн буюу барга ястныг хооронд нь хошуу, сумны нутгийн заагийг ашиглан нутаг билчээрийн асуудлаар маргалдаан болох зэрэг үл ялих асуудлыг хоёр улсын болон хоёр үндэстний асуудал мэт болгон хооронд нь эв найрыг нь эвдэн дайсагнах үзэл буй болгосоор ирсэн ул мөрийн үлдэгдлийг империалист японы ноёрхогчид, өөрийн колони болгон эзэмших бодлогоо явуулахдаа нийцүүлэн бичсэн нуршаа үг гэхээс цаашгүй билээ. Манж Чин улсын үед шинэ, хуучин бараг гэж тусгай хошууд буй болгосон шалтгаан нь XVII зууны үед Чивчин Барга (хуучин Барга) Баргуужины зэрэг урьдын нутгаасаа Бүхэ (Цичигэр) хот орчим газарт Манжийн шаардлагаар түрүүн нүүж очоод тэндээс 1732 (Манжийн Найралт төв хааны аравдугаар) онд Хөлөнбуйрын газар нүүж ирсэн учир хуучин Барга гэж нэрлэгджээ. Шинэ Барга нь Халхын Цэцэн хан

¹Юан улсын түүх. 30-р боть, 15-р тал (хятад хэлээр).

²Ояма. Хятад улсын гэр бүлийн байгууллын судлал. Токио. 1953, 192-р тал. (Япон хэлээр).

³«Монголын судлал», Улаанбаатар, 1971, № 8, 203—205-р тал.

⁴Материалы по Маньчжурии и Монголии. Выпуск второй. Барга и Халха. г. Харбин. 1905, 1—13-р тал (Орос хэлээр).

⁵Манж—Монголын бүрэн бичиг, 1921, 39—40-р тал. (япон хэлээр).

аймгийн Жанчивдоржийн хюшуунаас 1737 онд Хөлөнбуйр нутагт хожим нүүж очсон тул шинэ Барга гэж нэрлэсэн юм.

Манж Чин улсын феодалууд урьд хожид нүүж ирсэн барга ардыг манжийн найман хошуу болгон зохиоходоо «бүдүүлэг барга» гэж доромжлон нэрлэсэн явдал байгаа юм. Үүнд: Барга ардын барга хэмээх нэрийн үүслийн талаар дээрх олон эрдэмтэн нарын тайлбарлан бичсэн нь Хүннү улсын үеэс эхлэн баргуужин, XII зууны үеэс баргад хэмээж байгаад XVII зуунаас хойш бөөгийн шашинтан барга хэмээн олон янзаар нэрлэгдэж иржээ. Эдгээр баргын олон төлөөний нэрсүүдийг эрдэмтэд үгийн утгаар нь авч тайлбарлан нэрлэсэн нь заримдаа тохирох мэт боловч учхамдаа бараг ардын гарал, үүслийн талаар барга баатар, дайчин ноён¹ Хорилдо Мэргэний толгойлж байсан аймаг овгийн үр үндэс болохыг түүх нотолж байгаа учир барга гэгч нь өвөг дээдсийн нэрээр овоглон нэрлэж болохыг мөчид боловч дурдсангүй байна.

Хүн төрөлхтөн, түүний дотор монголчууд эрт үеэс өнөө үеийг хүртэл өөрсдийн үр ач хүүхэд, аймаг угсаа, үндэстэндээ нэр цол өгөхдөө хүч чадалтай байхыг илэрхийлж арслан, барс бат бэхээр явахыг билэгдэж Ганхуяг, Батзаяа, Төмөрбаатар, Алтанхуяг, урт удаан наслан амьдрахыг хүсэж Мөнхнасан, Уртнасан, Мөнхцэцэг гэх мэтчилэн билэг дэмбэрэлтэй нэрийг сонгон өгсөөр иржээ.

Гэтэл хятад сурвалж бичигт эртний Хятадын Шан улс, Жоу улсын үеийн «хунь-и»-г соёлгүй, бүдүүлэг «Сянюн-ийг» догшин араатан гэж тус тус нэрлэдэг байжээ. Үүнийг «Чунь цю» (Хавар намар улсын) үед цээрлэж, байлдаант улсуудын үед хүннүг «хэрцгий боол» гэх буюу хүннү нараас зүүн тийш оршин суусныг зүүн Ху буюу зүүн самуун дээрэм гэх зэргээр басамжлан нэрлэжээ. Мөн түүнчлэн Барга аймгийг тухайн нийгмийн байдлаар жишээлбэл: бүдүүлэг бөгөөд соёлгүй балай дүлий, харанхуй гэх мэтээр барга гэдэг үгийн утгыг тайлбарлажээ.

Харин «барга» хэмээх нэр нь бараг бүргийн бараг, барай бүрий, хар харанхуй гэсэн утгатай байж бас болохгүй гэх газаргүй юм. Монголын заншилд хар тэнгэр, шар газар гэж тэнгэр газрыг ялган тайлбарласан зүйл байдаг². Үүнд: эцэг тэнгэр, эх газар гэдэг шиг хар тэнгэр, шар газаргүй бол дэлхий ертөнц дээр түмэн бодис дэлгэрэн амьдарч чадахгүй учир тэнгэр газартай өнө үүрд байх утгатай байна. Баргачууд бөө мөргөлтэй байсан тул хар тэнгэрийн харын зүгийн бөө мөргөлөө хүндэтгэн үдшийн харанхуйн бүрий баруй (бараг)-ныг түрэг үгнээс гаралтай Борой (чоно буюу онгоны эзэн), Барха нохой хэмээх үгнүүдээс үндэслэж Барга (хар тэнгэрийн чоно) хэмээн нэрэлсэн байж бүрэн болно.

¹Н. О. Ивановский «Mangjurica», Ленинград. 1894, 4-р тал.

²Хятад хэлний том толь бичиг. 38-р боть, 499-р тал.